



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Төслийн явцын тайлан /2019 оны III улирал/

Улаанбаатар хот
2019.10.07



Товчилсон үгийн жагсаалт

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БУА	Барилга угсралтын ажил
ГМТХ	Газрын мэдээллийн технологийн хэлтэс
ГЧНШ	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт
ГЧХ	Газар чөлөөлөх хэлтэс
ЕХОБ	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХС	Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК
НАЗХГ	Нийслэлийн Авто зам хөгжлийн газар
НГА	Нийслэлийн Газрын алба
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
НОБГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
НӨАУГ	Нийслэлийн Өмч ашиглалт, удирдлагын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НХТЕТГ	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
УСУГ	Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ
СААХ	Санхүү, аж ахуйн хэлтэс
СБД	Сүхбаатар дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн Яам
УБДС	Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
УИХ	Улсын Их Хурал
УБХЗ	Улаанбаатар хотын захиргаа
ҮХС	Үерийн хамгаалалтын суваг
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХСГ	Хөгжлийн санхүүжилтийн газар
ХДС	Хамгаалалтын далан суваг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭХЯ	Эрчим Хүчний Яам

Тайлангийн агуулга

Үндсэн агуулга	Хуудас
1. Тайлангийн тойм	4
2. Хөтөлбөрийн I үе шат - Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд	6
2.1. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц	6
2.2. Худалдан авах ажиллагааны явц	8
2.3. Барилга угсралтын ажлуудын явц	9
3. Хөтөлбөрийн II үе шат - Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүд	15
4. Дүгнэлт ба тулгамдаж буй асуудлууд	19
5. Хавсралтууд	20
Хавсралт 1. Баянхошуу дэд төв – барилга угсралтын ажлын явцын зургууд	21
Хавсралт 2. Сэлбэ дэд төв - барилга угсралтын ажлын явцын зургууд	26
Хавсралт 3. ЕХОБ-ны санхүүжилттэй барилга угсралтын ажлын явцын зургууд	33

1. Тайлангийн тойм

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичигт заасан эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг МУ-ын УИХ-аар 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан.

“


Хөтөлбөрийн эрхэм зорилго нь гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулснаар Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгоход оршино.

”

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ) болон Улаанбаатар хотын захиргаа (УБХЗ) хамтран санхүүжүүлэх ба нийт 3 үе шаттайгаар 6 дэд төвийн суурь дэд бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэнэ.



Төсөл нь худалдан авалт, газар чөлөөлөлт, барилга угсралт гэсэн үндсэн 3 чиглэлийн үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг.





Тайлангийн хугацаанд төслийн хэрэгжилтийн явц 71.61%-д хүрсэн ба өмнөх оны эцэстэй харьцуулахад 16.78%, II улиралтай харьцуулахад 7.81%-иар тус тус нэмэгдсэн байна.

Тайлангийн хугацаанд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 97.42%-д хүрч, II улиралтай харьцуулахад 2.78%-иар ахисан ба хэрэгжилт удаашралтай байна. Энэ нь газар чөлөөлөлтийн явцад трасс өөрчлөгдөх, чөлөөлөх нэгж талбарууд нэмэгдсэнтэй холбоотой юм.

Худалдан авах ажиллагааны явц 99.12%-д хүрсэн ба II улиралтай харьцуулахад 1%-иар нэмэгдсэн байна. Барилга угсралтын ажлуудын нийт явц 65% буюу II улиралтай харьцуулахад 12%-иар өссөн байна.

❖ Төслийн санхүүжилт

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар Хөтөлбөрийн санхүүжилт, түүний ашиглалт, зарцуулалтын мэдээлэл:

Хөтөлбөрийн I үе шатны АХБ-ны MON-3099 (COL) зээлийн хүрээнд 7.0 тэрбум төгрөг, MON-3098 (OCR) зээлийн хүрээнд 9.2 тэрбум төгрөг, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны FI'83097 зээлийн хүрээнд 27.4 тэрбум төгрөгийн тус тус **ашиглалт** бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс **зарцуулалт** дараах байдалтай байна. Үүнд:

- АХБ-ны MON-3099 (COL) зээлийн эх үүсвэрээс 5.54 тэрбум төгрөг дэд төвүүдэд баригдаж буй нийгмийн байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт болон зөвлөх үйлчилгээний зардалд;
- АХБ-ны MON-3098 (OCR) зээлийн эх үүсвэрээс 11.00 тэрбум төгрөг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлд;
- ЕХОБ FI'83097 зээлийн эх үүсвэрээс 13.1 тэрбум төгрөгийг усан сан, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлын гүйцэтгэлд;
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт 17.99 тэрбум төгрөг газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор, түүний дэмжлэг болон инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний хамтарсан санхүүжилттэй гэрээт ажлуудын НЗДТГ-ын хариуцах хөрөнгө оруулалтын ажлуудад тус тус зарцуулагдсан байна. Батлагдсан төсвийн гүйцэтгэл 99.97% -тай байгаа нь 2019 оны IV улиралд хүлээгдэж буй төлбөрийн хүсэлтүүдийн санхүүжилтийг олгох боломжгүй байна.

Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд АХБ-ны MON-3526 (COL) зээлийн хүрээнд 11.55 тэрбум төгрөг, MON-3525 (OCR) зээлийн хүрээнд 11.19 тэрбум төгрөгийн **ашиглалт** бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс **зарцуулалт** дараах байдалтай байна. Үүнд:

- АХБ-ны MON-3526 (COL) зээлийн эх үүсвэрээс 3.76 тэрбум төгрөг Дамбадаржаа, Дэнжийн Мянга дэд төвүүдийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагчын хяналт тавих, Төсөл 3-ийн ТЭЗҮ боловсруулах болон институцийн чадавхийг бэхжүүлэх, төслийн хэрэгжилтийн хүрээнд үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр үзүүлж буй зөвлөх үйлчилгээний зардалд;
- АХБ-ны MON-3525 (OCR) зээлийн эх үүсвэрээс 1.37 тэрбум төгрөг Баянхошуу дэд төвд баригдаж буй дулааны шугам сүлжээ шинээр суурилуулах ажлын гүйцэтгэлд тус тус зарцуулагдсан байна.

2. Хөтөлбөрийн I үе шат - Баянхошуу, Сэлбэ дэд төв

2.1. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц

Төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг үндэслэн АХБ-ны Хамгааллын бодлого, журмын дагуу зохион байгуулахаар МУ-ын Засгийн газар үүрэг хүлээсэн ба үүнд холбогдох зардлыг нийслэлийн төсвөөс бүрэн хариуцаж Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.



Тайлангийн хугацаанд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц 97.42%-д хүрч өмнөх онтой харьцуулахад 8.5%, II улиралтай харьцуулахад 2.78%-иар тус тус өссөн байна.

Мөн нөлөөлөлд өртсөн айлуудтай зөвшилцөх ажлын явц 98.6%-тай буюу ажил дуусах шатандаа хэрэгжиж байна. Гэвч нөхөн олговрын төлөлт 94.6%-тай хэрэгжиж байгаа нь санхүүжилттэй холбоотой удаашралтай байна.

Одоогийн байдлаар Сэлбэ дэд төвийн 9, Баянхошуу дэд төвийн 8, Зүүн хойд бүсийн усан сангаас Тасган, 3,4 дүгээр хорооллын усан, Талх чихэр ХХК-ийн цэвэр усны шугамын шинэчлэл, бохир усны шугамын өргөтгөлийн ажлын нөлөөлөлд өртсөн 2, нийт 19 нэгж талбарын нөхөн олговрын захирамжийг гаргуулахаар холбогдох материалуудыг бүрдүүлэн Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2019 оны 06 дугаар сарын эхээр хүргүүлсэн боловч захирамж гарахгүй хүлээгдсээр байна. Хугацааны хувьд зөвшилцсон иргэдийн материалыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлснээс хойш дунджаар 3-4 сарын дараа захирамж гардаг ба нөхөн олговроо гэрээ байгуулснаас хойш сар илүү хугацааг зарцуулж байгаа нь барилга угсралтын ажлыг хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэсээр байна.

I. Кадастрын зургийн өөрчлөлт:

Дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлын трасст хагас өртөж газраа чөлөөлсөн нийт 260 нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлснийг 08 дугаар сараас эхлэн хийж байгаа бөгөөд 120 гаруй нэгж талбарын өөрчлөлт хийгдээд байна.

Нөлөөлөлд хагас өртсөн айлуудын кадастрын зураглал, гэрчилгээг шинэчлэн гаргуулахаар нийт 144 гаруй айлуудын бүртгэлийн материалуудыг бэлтгэж, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэхээр эцэслэн бэлтгэж байна.

II. Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй иргэдэд газар олгох:

АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын дагуу боловсруулан баталсан “Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө” -нд заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөж, нүүх шаардлагатай болсон өөрийн гэсэн газрын эрхгүй өрх тус бүрд одоогийн амьдарч буй газраас нь дордуулахгүй нөхцөлтэй газар олгох шаардлагатай гэж заасан байдаг. Энэ заалтыг биелүүлээгүйн улмаас АХБ-наас төслийг 2 сар орчим хугацаанд зогсоосон болно.

Төслийн хүрээнд нөлөөлөлд өртсөн нийт 907 нэгж талбарын 420 нь газраа бүтэн чөлөөлж байгаа бөгөөд 48 хувь нь хашаандаа хоёроос дээш өрхтэй амьдарч байсан. Иймээс урьдчилсан байдлаар газрын эрхгүй амьдарч байгаад нүүсэн болон нүүх шаардлагатай болсон 253 өрх байна.

Дээрх 253 газрын эрхгүй өрхүүдэд суурь дэд бүтцээр хангагдсан нийтийн үйлчилгээтэй газар олгох эсвэл зорилтот бүлгийн орон сууц санал болгох зэрэг боломжит хувилбаруудыг баталгаажуулж, тухайн иргэдтэй зөвшилцөн сонгосон хувилбаруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар НЗДТГ, НГЗБА, НОСК ХК, Төсөл хэрэгжүүлэх нэгж, нийслэлийн Засаг даргын 2018 оны захирамжаар



байгуулагдсан ажлын хэсэг хамтран ажиллах ажлын удирдамжийг нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалан даргаар батлууллаа. НӨАУГ-аас ирүүлсэн БЗД, СБД, ЧД, СХД-ийн 47 байршил, Хан-Уул дүүргийн Морингийн даваа байршлуудыг нэг бүрчлэн очиж айл амьдрах боломжтойг судалж, НӨАУГ-т 35 байршлыг сонгож, эзэмших эрхээсээ татгалзах тухай албан хүсэлтийг хүргүүлээд байна.

Ш. Нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн олговрын зөрүүг олгох:

2018 оны 4 дүгээр сард нөлөөлөлд өртөгч иргэдийн АХБ-ны Хариуцлагын газар гаргасан гомдлын дагуу НЗДТГ, АХБ-ны төлөөлөл, Төсөл хэрэгжүүлэх нэгж, иргэд, төрийн бус байгууллагууд зэрэг талууд оролцсон “Санамж бичиг”-ийг олон удаагийн уулзалт, хэлэлцээрийн дараа 07 дугаар сарын 2-нд байгуулсан. Уг баримт бичгийн дагуу иргэдийн газрын үнэлгээг Сэлбэ дэд төвд 1 м2 нь 80.000 төгрөг, Баянхошуу дэд төвд 1 м2 нь 60.000 төгрөгөөр тооцож авах, шилжилтийн үеийн дэмжлэг 1.800.000 төгрөг, нүүх зардал 250.000 төгрөгийг нүүж байгаа айл бүрт нөхөн олговор болгон олгохоор тогтсон.

Дээрх ажлын дагуу Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нөлөөлөлд өртсөн нийт 473 нэгж талбар дээр газрын үнэлгээ нэмэгдсэнтэй холбоотой нэмэлт төлбөр, нүүлгэлтийн зардал, амьжиргааг дэмжих шилжилтийн үеийн дэмжлэг зэрэг нөхөн олговрын захирамжийг гаргуулж, нийт 401 айлтай нөхөн олговрын гэрээ байгуулж, одоогийн байдлаар 120 айл өрхийн нөхөн олговор олгогдоход бэлэн болсон байна.

Доорх хүснэгтээр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явцын мэдээллийг дэлгэрэнгүй харуулав.

2019 оны 9-р сарын 30-ны байдлаар

№	Байршил	Ажлын нэр	Нөлөөлөлд өртсөн нийт нэгж талбар	Зөвшилцсөн	НЗД-ын Захирамж гарсан	НЗД-ын Захирамжийн төслийн санал	Зөвшилцөө-гүй үлдсэн	Нөхөн төлбөр төлөгдсөн нэгж талбар
1	Баянхошуу дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	338	337	333	8	1	329
		Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ-ын дэд өртөө	27	27	27	0	0	27
		Усан сан	13	13	13	0	0	13
		Дулааны төвлөрсөн дулаанд холбох 3.2 км шугам	43	42	42	1	0	42
2	Сэлбэ дэд төв	Зам, инженерийн шугам сүлжээ	332	325	313	9	6	305
		Дулааны станц	27	27	27	0	0	27
		Цэцэрлэг, МСҮТ	19	19	19	0	0	19
3	КТМС-с Талх чихэр хүртлэх цэвэр болон бохир усны 11 км шугам		11	8	6	2	3	4
4	Баянхошуу, Сэлбэ дэд төв	Бохир усны коллекторын ажил	94	94	94	0	0	90
Нийт			904	892	874	20	10	856

2.2. Худалдан авах ажиллагааны явц



Хөтөлбөрийн I үе шатны хүрээнд АХБ болон ЕХОБ-ны санхүүжилтийн 4 төрлийн эх үүсвэрээс нийт 30 худалдан авалтын багц байгаагаас 2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар 26 багцын худалдан авах ажиллагааг гүйцэтгэж, гэрээ байгуулсан.

Тайлангийн хугацаанд төслийн худалдан авах ажиллагааны явц 99.12%-тай хэрэгжиж байна. 2019 онд худалдан авах ажиллагааны хүрээнд 3 багц гэрээ байгуулсан ба Сэлбэ дэд төвд баригдаж буй цэцэрлэг, бизнес

инкубаторын тавилга тоног төхөөрөмжийн худалдан авах ажлуудыг 2019 оны IV дүгээр улиралд гүйцэтгэхээр төлөвлөсөн.

2019 оны 9-р сарын 30-ны байдлаар

Зарласан огноо	ХАА-ны багцын дугаар, нэр	Төлөв
2019.04.26	WSC16A: Баянхошуу дэд төвийн усан хангамж, ариутгах тасстурга, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, бараа тоног төхөөрөмж нийлүүлэх болон суурилуулах ажил /Түлхүүр гардуулах нөхцөлтэй/	2019.07.24-ний өдөр гэрээ байгуулагдсан.
2019.05.28	BSLS09 Багц 1 (дахин зар): Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын суваг дагуух талбайн тохижилтын ажил	2019.08.02-ний өдөр гэрээ байгуулагдсан.
2019.05.31	BSDF07B (дахин зар): Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил	2019.08.20-ний өдөр гэрээ байгуулагдсан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тайлангийн хугацаанд нийт 1 багц зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг гүйцэтгэж, гэрээний хэлэлцээр эхлүүлэхээр бэлтгэж байна. Уг зөвлөх үйлчилгээ (ЗҮ5)-ний сонгон шалгаруулалтыг НХААГ зохион байгуулж гүйцэтгэсэн бөгөөд сонгон шалгаруулалтыг эцэслэхэд нийт 1123 хоног зарцуулсан байна. Гэрээний хэлцлийг хийж гэрээг эцэслэн АХБ-аар баталгаажуулах ажил хийгдэж байна.

2.3. Барилга угсралтын ажлын явц



Тайлангийн хугацаанд Барилга угсралтын ажлуудын нийт явц 65% буюу өмнөх улиралтай харьцуулахад 12%-иар өссөн байна.

Доорх хүснэгтэд барилга угсралтын ажлын явцын мэдээллийг дэлгэрэнгүй гэрээ тус бүрээр харуулав.

Барилга угсралтын ажлын явцын мэдээлэл /2019.09.30/

№	Гэрээний дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Бодит явц %	Дэлгэрэнгүй мэдээлэл
1. Баянхошуу дэд төв				
1.1	ВНФ06 <i>/Гүйцэтгэгч: “ЧММ” ХХК, “Эс Энд Эй Трейд” ХХК-уудын түншлэл/</i>	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	100%	<ul style="list-style-type: none"> Дулааны 11и магистраль шугамыг өргөтгөх ажлын хүрээнд 2ф700мм-ийн диаметртэй 1,6 км шугам, 2ф600мм-ийн диаметртэй 1,6 км шугамын ажлуудыг бүрэн хийж дуусгасан. Тохижилт, нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. 2019.09.06-ны өдөр байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажилласан. 2019.09.18-ны өдөр байнгын ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт баталгаажсан.
1.2	ВНФ06В <i>/Гүйцэтгэгч: БНСУ-ын “Жангхан Инженеринг” ХХК, КДНЕС ХХК, болон Одкон Холдинг ХХК-уудын түншлэл/</i>	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах шинэ дулааны магистраль шугамын ажил	63%	<ul style="list-style-type: none"> Гадна дулааны шугамын ажлын зураг төслийг магадлалаар батлуулсан. Даралт өргөх насос станц, Ус дулаан дамжуулах төвийн барилга угсралт болон дулаан механикийн ажлын зураг төслийг боловсруулж дуусгасан. Барилгын зураг төслийг НОБГ-тай зөвшилцөж, магадлалаар батлуулахаар хянуулж байна. Шинээр хийх гадна дулааны 2ф600мм-ийн диаметртэй 0.5 км шугам, 2ф400мм-ийн 0.4 км шугамын угсралтын ажил хийгдсэн. Насос станц, ус дулаан дамжуулах төвүүдийн барилга угсралтын ажил хийгдэж байна.
1.3	ВЕС13 <i>/Гүйцэтгэгч: Одкон Холдинг ХХК, Одкон Эрчим ХХК-ийн түншлэл/</i>	Баянхошуу дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил	58%	<ul style="list-style-type: none"> Ажлын зураг, төсөв боловсруулж батлуулах: Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний зураг экспертизээр хянагдаж байгаа. Ажлын зургийн дагуу төсөв хийгдэж магадлалаар хянуулж байна. Барилга угсралтын ажил: 35/10кВ-ийн дэд станцын барилгын ажил 70%, 2 ш хаалттай дэд өргөөний барилгын ажил дууссан, 10кВ-ийн хуваарилах байгууламжийн барилгын суурийн ухлагын ажил хийгдсэн/ хажуугийн айл гомдол гаргаснаас ажил зогссон/, Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын суурийн ухлагын ажил хийгдсэн /нэмэлт газар чөлөөлөлт хийгдэж байгаа/, 35кВ-ийн кабель шугамын ажил авто зам доогуур сүвлэгээ хийх зөвшөөрөл хүлээгдэж байна. Дотоодоос нийлүүлэх материалын худалдан авалт - 80% Гадаадаас нийлүүлэх материалын худалдан авалт - 20% /Бүх шаардлагатай тоног төхөөрөмжүүд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн, УБЦТС ТӨХК, НХОГ-н хяналтын инженерүүд үйлдвэрлэлийн хяналтыг БНХАУ явж хийсэн/
1.4	BRDH11	Баянхошуу дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон	35%	<ul style="list-style-type: none"> Хийгдэж буй ажлууд: <ul style="list-style-type: none"> - Ариутгах татуургын шугамын угсралтын ажил - Цахилгааны шугам зөөж шилжүүлэх ажил

	<i>Гүйцэтгэгч: БНХАУ-ын Yancheng Xingguo Construction Engineering Co.,Ltd/</i>	бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил, хэсэг-1		<ul style="list-style-type: none"> - Дулааны шугамын материал татан авалтын ажил - Дулааны шугамын өөрчлөлтийн зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх ажил. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 98.8%-тай хэрэгжиж байгаа ба нэмэлт газар чөлөөлөлт хийгдсэн.
1.5	BRDH14 <i>Гүйцэтгэгч: ХБНГУ-ын Ludwig Pfeiffer- Pfeiffer Leipzig түншлэл/</i>	Баянхошуу дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил, хэсэг-2	29%	<ul style="list-style-type: none"> • Хийгдэж буй ажлууд: <ul style="list-style-type: none"> - Цахилгааны зөөж шилжүүлэх ажил - Дулааны шугамын материал татан авалтын ажил - Дулааны шугамын өөрчлөлтийн зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх ажил - Ажил эхлүүлэх зөвшөөрлийн холбогдох баримт бичгийг НХБХГ-т хүргүүлэв. • Цэвэр усны шугамын барилга угсралтын ажил 89.5%-тай хийгдэж байна. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 98.8%-тай байна.
1.6	PP01-SW	Баянхошуу дэд төвд баригдах Орлогод нийцсэн орон сууцны туршилт, 20 айлын орон сууц	10%	<ul style="list-style-type: none"> • Баянхошуу дэд төв, Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, Баянцагааны 10 гудамжинд “Улаанбаатар хотын иргэдийн орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл” төслийн туршилтын 20 айлын загвар орон сууцыг барилгын зураг төсөл төсвийг бүрэн боловсруулж, барилгын зураг төсөл зөвшилцөх ажил бүрэн дуусч, барилгын зураг төслийг Барилгын хөгжлийн төвд магадлалаар батлуулахаар өгөөд байна. Барилгын гадна инженерийн шугам сүлжээг ашиглагч байгууллагуудтай зөвшилцөөд явж байна. • 2019.06 сард нөлөөлөлд өртсөн айлуудтай зөвшилцөж, газар чөлөөлөлтийг бүрэн хийж, архитектур төлөвлөлтийн даалгаврыг НХБХГ-с авсан. Зураг төслийн компани болон ГХН-н худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүд уг ажлын тендерийн баримт бичгийг боловсруулж байна.
1.7	BSLS09 Багц 1 <i>Гүйцэтгэгч: “Дүүрэн Трейд” ХХК, “Байгууламж” ХХК-ийн түншлэл/</i>	Баянхошуу дэд төвийн тохижилтын ажил	32%	<ul style="list-style-type: none"> • Тендерийн үнэлгээ хийгдэж хамгийн сайн үнэлэгдсэн “Дүүрэн Трейд” ХХК, “Байгууламж” ХХК-ийн түншлэл шалгарч 2019.08.02-ны өдөр гэрээ байгуулав. • Ажлын талбайн бэлтгэлийг хангаж, ажил эхлүүлэхэд бэлэн болсон. • Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн хүсэлт, холбогдох материалуудыг 2019.08.13-ны өдөр хүргүүлсэн боловч зөвшөөрлийн гэрчилгээ хэвлэдэг үнэт цаас дууссан шалтгаанаар хүлээгдэж байна.
1.8	BSDF07B <i>Гүйцэтгэгч: “Монгол Менежмент төв” ХХК, “Улаанбаатар Менежмент ХХК”-ийн түншлэл/</i>	Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил	15%	<ul style="list-style-type: none"> • Тендерийн үнэлгээ хийгдэж хамгийн сайн үнэлэгдсэн “Монгол Менежмент төв” ХХК, “Улаанбаатар Менежмент” ХХК-ийн түншлэл шалгарч 2019.08.20-ны өдөр гэрээ байгуулав. • Ажлын талбайн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
1.9	BSF05 Багц 1 <i>Гүйцэтгэгч: Ус Орчин ХХК/</i>	Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил	100%	<ul style="list-style-type: none"> • 2018.11.16-ны өдөр уг барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комисс амжилттай ажиллаж, ашиглагч 261 дүгээр цэцэрлэгт багш хүүхдийн иж бүрэн тавилга, гал тогооны төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгсөн.
1.10	BSF05 Багц 2 <i>Гүйцэтгэгч: Томо Библинг ХХК, Би Эм Си Эм ХХК-ийн түншлэл/</i>	Баянхошуу дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил	100%	<ul style="list-style-type: none"> • Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт Бизнес инкубатор, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгыг 2019 оны 03 сард барьж дуусгасан. • Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянцагааны 10 дугаар гудамжинд Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгыг 2019 оны 03 сард барьж дуусгасан. Гэвч тухайн барилгыг ашиглагч, эзэмшигч байгууллагыг тодорхойлох асуудал, Нийслэлийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөний улмаас захирамж гарах процесс сунжирч, 2019.05.15-ны өдөр А/455тоот ашиглагч байгууллагыг тодорхойлсон захирамж гарч, улмаар байнгын ашиглалтад оруулах улсын комисс 2 сарын дараа буюу 2019.05.24-ний өдөр ажилласан.



				<ul style="list-style-type: none"> Тус А/455 тоот захирамжид тухайн барилгын цаашдын ашиглагч, үйлчилгээг хариуцагч байгууллагаар НӨАУГ-г тодорхойлсон боловч, НӨАУГ нь манай байгууллагын үндсэн чиг үүрэгт барилга байгууламжийн үйлчилгээг хариуцдаггүй хэмээн НӨАУГ-с 2019.06.28-ны 4/777 тоот албан бичгээр мэдэгдсэн. Нийслэлийн засаг даргын 2019.08.13-ны өдрийн А/819 тоот захирамжаар ашиглагч, үйлчилгээг хариуцагч байгууллагаар Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний Газар байхаар А/455 тоот захирамжид өөрчлөлт оруулсан. Барилгад нийлүүлж суурилуулах тоног төхөөрөмж, тавилгыг 4-р сарын 18-нд нийлүүлж угсарч суурилуулахад бэлэн болсон боловч НӨАУГ тухайн барилгыг хариуцах ажилтныг томилоогүйн улмаас тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг угсарч суурилуулах ажил хойшлогдоод байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан
2. Баянхошуу дэд төв /ЕХОБ-ны Ус хангамжийн ажлууд/				
2.1	BSWR10 Багц 1 <i>/Гүйцэтгэгч: Бумбод ХХК, Одкон Холдинг ХХК-ийн түншлэл/</i>	Баянхошуу дэд төвд барьж буй 1000 м3 усан сан, насос станцын 2 барилгын угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил	79.1%	<ul style="list-style-type: none"> Хийгдэж буй ажлууд: <ul style="list-style-type: none"> Усан сан, 1000м3 – 85% Насос станц, 1ш – 90% Өргөлтийн насос станц, 1ш – 80% Ус дамжуулах шугам, 5.6 км – 90% гүйцэтгэлтэй тус тус хийгдэж байна. Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Усан сангийн туршилт тохируулга хийгдэж байна. Насос станц-1, насос станц /өргөлтийн/ барилга угсралтын ажил, насос суурилуулалтын ажил хийгдэж байна.
2.2	WSC16A <i>/Одкон Холдинг ХХК, Улаанбаатар Барилга ХХК-ийн түншлэл/</i>	Баянхошуу дэд төвийн усан хангамж, ариутгах татуурга, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, бараа тоног төхөөрөмж нийлүүлэх болон суурилуулах ажил	38.5%	<ul style="list-style-type: none"> 2019.04.26-ны өдөр тендер зарлан үнэлгээ хийгдэж хамгийн сайн үнэлэгдсэн “Одкон Холдинг” ХХК, “Улаанбаатар Барилга” ХХК-ийн түншлэлтэй 2019.07.24-ний өдөр гэрээ байгуулав. Хилчин хогхоньг төвлөрсөн дулаанд холбох дулааны шугамын барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дуусав.
2.3	NCB-BCM1/ BCM2 <i>/Гүйцэтгэгч: Бумбод ХХК, Ди Вай Кэй Би ХХК-ийн түншлэл/</i>	Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах Бохирын гол шугам	100%	<ul style="list-style-type: none"> Баянхошуу дэд төвийг холбосон ариутгах татуургын коллектор шугам: <ul style="list-style-type: none"> 4116 м DN 450 & 500 –ийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн хоолой; 2250 м DN 600 –ийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн хоолойг тус тус угсарч суурилуулав. 2017.12 сард байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллав.
2.4	BSDF07 Багц 1 <i>/Гүйцэтгэгч: Хангилцаг ХХК/</i>	Баянхошуу дэд төвд баригдах үерийн хамгаалалт, далан суваг	100%	<ul style="list-style-type: none"> Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажлыг 100% гүйцэтгэж, 2018.10.02-ны өдөр байнгын ашиглалтад оруулах Улсын Комисст ажиллаж ашиглагч байгууллага болох Нийслэлийн геодези, усны барилга байгууламжийн газарт хүлээлгэн өгсөн.
3. Сэлбэ дэд төв				
3.1	SBR08 <i>/Гүйцэтгэгч: ЗМЗ ХХК/</i>	Сэлбэ дэд төвд баригдах 24м, 30м, 60м-ийн урттай 3 ширхэг төмөр бетон гүүрийн барилгын ажил	71%	<ul style="list-style-type: none"> Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. <ul style="list-style-type: none"> 60 м урттай гүүрийн барилга угсралтын ажил – 80% 30 м урттай гүүр – 55% 24 м урттай гүүр – 80% гүйцэтгэлтэй байна.
3.2	SRDH11 <i>/Гүйцэтгэгч: Вайт Финикс ХХК, Хасу Мегаватт ХХК, Эвт Трак ХХК-ийн түншлэл/</i>	Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил, хэсэг-1	57%	<ul style="list-style-type: none"> Хөрсний усны түвшин доошлуулах ажлын материалын захиалгыг хийсэн, нийлүүлэлт хүлээгдэж байна. Хөрсний усны шугамын барилга угсралт хийгдэж байна. Газар чөлөөлөлт, нүүлгэж шилжүүлэлтээс шалтгаалж, огт зөвшилцөхгүй айлуудтай хэсэгт зураг төслийн тодорхой өөрчлөлтүүд хийгдэх зайлшгүй шаардлагууд гарч байна. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн зөвшилцөх явц, нөхөн олговор олгох явц удаашралтай байсан хэдий ч дээрх түншлэл нь 2018 оны барилга угсралтын улиралд чөлөөлөгдсөн нэгж талбарыг бүрэн цэвэрлэж, авто зам шугам сүлжээний трасст өртсөн цахилгаан холбооны



				<p>шугамыг зөөж шилжүүлэх ажлыг 95%-тай хийн бэлтгэл ажлыг хангасан.</p> <ul style="list-style-type: none"> • Нийт 8 УДДТ барихаас 6 барилгын угсралтыг хийж, дотор заслын ажил хийгдэж байна. Сүүлд газар чөлөөлөлт хийгдсэн УДДТ №1 барилгын суурийн ажил, УДДТ №4 барилгын 1-р давхрын карказын ажил хийгдэж байна. • Тайлангийн хугацаанд Сэлбэ дэд төвийг Чингэлтэйн төвийн ус, дулаантай холбох дулааны төв шугамын угсралтын ажлыг 7 буудлын төв зам дагуу 5 буудлаас 7 буудлын уулзвар хооронд 3 цэгт зам сэтгэлгээ хийх болсон тул 2019.09.20-ны өдрөөс 2019.09.22-ны өдрийн хооронд авто замын хөдөлгөөнийг хаасан. Шугам сүлжээний ажлыг суурилуулж дуусаад, замын нөхөн сэргээлтийг хийж, 2019.09.22-ны 02:00 цагт зам нээсэн. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 95.9%-тай байна.
3.3	SRDH14 <i>/Гүйцэтгэгч: Набсан ХХК, Тэргүүн инвест ХХК, Тэгш плант ХХК-уудын түншилэл/</i>	Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон бусад дэд бүтцийн шугам сүлжээний ажил, хэсэг-2	43%	<ul style="list-style-type: none"> • 2018 онд барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад хөрсний усны түвшин тооцоолсноос өндөр гарсан. Иймд тайлангийн хугацаанд хөрсний ус зайлуулах шугамын ажлыг эхлүүлсэн. • Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн зөвшилцөх явц, нөхөн олговор олгох явц удаашралтай байсан хэдий ч дээрх түншлэл нь 2018 оны барилга угсралтын улиралд чөлөөлөгдсөн нэгж талбарыг бүрэн цэвэрлэж, авто зам шугам сүлжээний трасст өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх ажил хийгдэж байна. • Тэргүүн Инвест ХХК-ний гүйцэтгэж байгаа дулааны шугамын угсралтын ажлын гагнуурын чанарын үл тохирол илэрсэн. Гагнуурын үл тохирлыг засах ажлаас шалтгаалан буцаан булалтын ажлын хугацаа 3 хоногоор хойшилсон. • Тайлангийн хугацаанд Сэлбэ дэд төвийг Чингэлтэйн төвийн ус, дулаантай холбох дулааны төв шугамын угсралтын ажлыг 7 буудлын төв зам дагуу 5 буудлаас 7 буудлын уулзвар хооронд 3 цэгт зам сэтгэлгээ хийх болсон тул 2019.09.20-ны өдрөөс 2019.09.22-ны өдрийн хооронд авто замын хөдөлгөөнийг хаасан. Шугам сүлжээний угсралт суурилуулалтын ажлыг дуусгаад замын нөхөн сэргээлтийг хийж, 2019.09.22-ны 02:00 цагт авто замыг нээсэн. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 95.9%-тай байна.
3.4	SHF06 <i>/Гүйцэтгэгч: "Хүрд" ХК, "Шинишан Гонгшен бойлер" ХХК-ийн түншилэл/</i>	Сэлбэ дэд төвд 28 Мвт дулааны станцын барилгын зураг төсөл, ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажил	52.2%	<ul style="list-style-type: none"> • Дулааны станцын барилгын суурь, 3 зуухны суурийн ажил, суурийн нягтруулгын ажил, нүүрсний агуулахын барилгын суурийн ажил хийгдсэн. • 3 зуухны босоо ган тулгууруудын угсралтын ажил хийгдсэн. Шат тавцан гагнаж суурилуулах ажил үргэлжилж байна. • 2019.09.25-ны өдрийн байдлаар 45 ажилтан төслийн талбайд ажиллаж байна. Графиктай уялдуулсны дагуу 100-аас дээш ажилтан шаардлагатай. Гагнуурын ажлуудаас хамааран ажил удааширч байгаа тул гагнуурчдын орон тоог яаралтай нэмэх шаардлагатай. Үүний дагуу гүйцэтгэгч компанид 2019.08.20-ний өдөр албан бичиг илгээсэн боловч бичгийн хариуг ирүүлээгүй байна.
3.5	SEC13 <i>/Гүйцэтгэгч: Дорнын Их Гэгээ ХХК, Монхас ХХК-ийн түншилэл/</i>	Сэлбэ дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил	49%	<ul style="list-style-type: none"> • Ажлын зураг, төсөв боловсруулж батлуулах: Ажлын зургууд батлагдаж магадлалаар орсон. Ажлын зургийн дагуу төсөв хийгдэж магадлалаар хянагдаж байна. • Барилга угсралтын ажил: 35/10кВ-ийн дэд станцын барилгын ажил 30%, 2 ш хаалттай дэд өргөөний барилгын ажил 80%, Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын ажил 50%, 35кВ-ийн кабель шугамын ажил 33%. • Дотоодоос нийлүүлэх материалын худалдан авалт - 50% • Гадаадаас нийлүүлэх материалын худалдан авалт - 20% /Шаардлагатай бүх тоног төхөөрөмжүүд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн, УБЦТС ХК-аас үйлдвэрүүдэд очиж хяналт хийсэн./
3.6	SSF05 Багц 1	Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн	52%	<ul style="list-style-type: none"> • Нийслэлийн бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор 2019.03.15-ны өдөр хүргүүлсэн барилгын



	<i>/Гүйцэтгэгч: Цаст Констракшн ХХК/</i>	цэцэрлэгийн барилга угсралтын ажил		ажил эхлүүлэх зөвшөөрөл 2019.05.07-нд гарсны улмаас барилга угсралт оройтож эхэлсэн. Барилга угсралт эхэлснээс хойш барилгын талбайд өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх, барилгын газар шороо, суурь, 2 давхар төмөрбетон карказын ажил бүрэн дуусч өрлөгийн ажлыг эхлүүлээд байна. • Барилгын талбайд өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх, барилгын түр хашаа татах, түр цахилгааны техникийн нөхцөл авах, гүйцэтгэгч түр кемп барих ажлыг хийж, барилгын суурийн ажил бүрэн дууссан. • 1 дүгээр давхрын хэв, арматур угсарч, 2 дугаар давхрын хучилтын хэв хашмалын ажил хийгдсэн.
3.7	SSF05 Багц 2 <i>/Гүйцэтгэгч: Бридж Констракшн ХХК, Монхас ХХК-ийн түншилэл/</i>	Сэлбэ дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажил	43%	• Нийслэлийн бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор 2019.03.15-ны өдөр хүргүүлсэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл 2019.05.07-нд гарсны улмаас барилга угсралт оройтож эхэлсэн. Барилга угсралт эхэлснээс хойш барилгын талбайд өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх, барилгын газар шороо, суурь, 2 давхар төмөрбетон карказын ажил бүрэн дуусч өрлөгийн ажлыг эхлүүлээд байна. • Барилгын сууринд 7 зэргийн хатуу, хадан хөрс гарсны улмаас сууринд 1 сар орчим хугацаа алдсан. • А блокийн 1 дүгээр давхрын хэв, арматур угсарч, 2 дугаар давхрын бетон арчилгаа хийгдэж байна. • Б блокийн 1 дүгээр давхрын хэв, арматур угсарч, бетон цуггалтын ажил хийгдсэн.
3.8	BSLS09 Багц 2 <i>/Гүйцэтгэгч: Бодь Пропертийз ХХК/</i>	Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон ҮХС-ийн хамгаалалтын хайсны угсралт суурилуулалтын ажил	33%	• Сэлбэ дэд төвийн үерийн далан дагуух тохижилтын ажлын гүйцэтгэгчээр “Бодь Пропертийз” ХХК шалгарч, 2019.03.25-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. • Ажлын талбайг хэсэгчилж 2019.05.22-нд хүлээлгэн өгсөн ба бэлтгэл ажлуудыг бүрэн хангасан. • 2019.07.14-ний өдрөөс ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.
4. Сэлбэ дэд төв /ЕХОБ-ны Ус хангамжийн ажлууд/				
4.1	BSWR10 Багц 2 <i>/Гүйцэтгэгч: Санжам ХХК/</i>	Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил	92%	• Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж дууссан байна. • 2019.08.31-ний байдлаар нийт барилга угсралтын ажил 100% бүрэн дууссан. Туршилт, тохируулга, угаалга шахалт, тест хийх ажил бэлэн болсон. • Туршилт тохируулга, шугамын угаалга шахалт, тест хийх ажил хийх үлдээд байна.
4.2	BSDF07 Багц 2 <i>/Гүйцэтгэгч: Экспресс зам ХХК/</i>	Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон ҮХС-ийн хамгаалалтын хайсны угсралт суурилуулалтын ажил	79%	• Бэлтгэл ажил бүрэн хангагдсан. • Барилга угсралтын ажил Вайт Финикс ХХК-ийн гүйцэтгэж байгаа инженерийн шугам сүлжээ болон дэд бүтцийн ажлуудаас хамааран хүлээгдэж байна. Барилга угсралтын ажлын технологийн дарааллаар хөрсний усны шугамын барилга угсралтын ажил хийсний дараа авто замын далан болон үерийн хамгаалалтын сувгийн ажлууд хийгдэнэ.
4.3	BSPE <i>/Гүйцэтгэгч: ЧММ ХХК/</i>	Сэлбэ, Баянхошуу дэд төвд ус хангамж, ариутгах татуургын яндан хоолой нийлүүлэх	100%	• 2018.04 сард бараа материалуудыг нийлүүлж хүлээлгэн өгсөн.
4.4	NCB-SCM <i>/Гүйцэтгэгч: Бумбод ХХК, Ди Вай Кэй Би ХХК-ийн түншилэл/</i>	Сэлбэ дэд төвд баригдах Бохерын гол шугам	100%	• Барилга угсралтын ажил бүрэн дууссан. • 2017.12 сард барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллав.
5. ЕХОБ-ны Ус хангамжийн ажлууд /Дэд төвүүдийн нутаг дэвсгэрээс гадна/				
5.1	WWTP01 <i>/Гүйцэтгэгч: Эс Энд Эй Трейд ХХК, Набсан ХХК-ийн түншилэл/</i>	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон азротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил	100%	• Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. • Төв цэвэрлэх байгууламжид осол гарсантай холбоотойгоор ажлыг түр зогсоосон тул гэрээний хугацааг үүнтэй уялдуулан сунгах шаардлага үүссэн. • Барилга угсралтын ажил бүрэн дууссан, улсын комисст хүлээлгэн өгөх акт зурагдаж байна.
5.2	WSNR17C	Улаанбаатар хотын Орос 14-р сургууль	100%	• Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХБХГ-аас 2018.07.17-ны өдөр авч барилга угсралтын ажлыг

	<i>/Гүйцэтгэгч: Модерн Хас ХХК, Монгол Менежмент Төв ХХК/</i>	орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил		эхлүүлсэн. 543 метр урттай Ф400мм-ийн зөөлөн ширмэн ариутгах татуургын шугамаас 460 метр шугам суурилуулав. • Барилга угсралтын ажил дууссан. 2019.07.16-ны өдөр байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөв.
5.3	WSNR17B <i>/Гүйцэтгэгч: Монинжбар ХК, Эн Эй Би ХХК/</i>	Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил	39%	• 2018 онд цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийсэн. 2019 оны I улиралд барилга угсралтад бараа материалыг нөөцлөх ажлыг зохион байгуулж ажилласан. • 2019.09.30-ны байдлаар ф600мм HDPE шугам суурилуулалт 2300м суурилуулаад байна. Шугам суурилуулалтын ажил 33%-тай хэрэгжиж байна. • Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлаас шалтгаалан барилга угсралтын ажил удааширч зургийн өөрчлөлтүүд хийгдсэн. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 81.8%-ийн явцтай байна. • НАЗХГ-тай авто замын холбогдолтой ажлуудад хамтран ажиллах шаардлагатай байна.
5.4	WSNR17A <i>/Гүйцэтгэгч: Грийн Ресурс ХХК/</i>	Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын болон “9Б” бохир ус зайлуулах шугамын барилга угсралтын ажил	25%	• Гүйцэтгэгч Грийн Ресурс ХХК зүгээс энэ онд цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийж гүйцэтгэв. • Барилгын ажилд ашиглагдах бүх бараа материалыг өвлийн улиралд татан авч нөөцлөх ажлыг зохион байгуулсан. • 2019.09.30-ны байдлаар ф900мм HDPE шугам суурилуулалт 100м суурилуулаад байна. • Мөн газар чөлөөлөлт, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажлууд удааширталтай байгаагаас гүйцэтгэгч байгууллага гэрээт ажлаа гүйцэтгэх нөхцөл боломжоор хангагдах боломжгүй байдал бий болж хугацааны хувьд хоцрогдол үүсч байна. • Газар чөлөөлөлт бүрэн хийгдэж дуусаагүй, 81.8%-ийн явцтай байна. • НАЗХГ-тай авто замын холбогдолтой ажлуудад хамтран ажиллах шаардлагатай байна. Тухайлбал НАЗХГ гүйцэтгэгч байгууллагад шугам суурилуулсан авто замын 1-р эгнээг бус тухайн чиглэлийн бүх эгнээг хучих шаардлага тавьж буйгаас авто замтай хэсэгт шугам суурилуулалтын ажлыг хийж чадахгүй нөхцөл байдал үүсээд байна.
5.5	WWOI <i>/Гүйцэтгэгч: Комфорт Импекс ХХК/</i>	УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах (Буцалтгүй тусламж)	100%	• Барилга угсралтын ажил бүрэн дууссан. • 2018.11 сард байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллав.



3. Хөтөлбөрийн II үе шат - Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүд

Зөвлөх үйлчилгээ

Хөтөлбөрийн үе шат 2-ын хүрээнд (i) инженерийн нарийвчилсан зураг төсөл болон барилга угсралтын хяналтын зөвлөх үйлчилгээ, (ii) төсөл хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг АХБ-ны Зөвлөх сонгон шалгаруулах журмын дагуу зохион байгуулж 2018.11.16-ны өдөр, 2019.01.04-ний өдөр тус тус гэрээ байгуулав.

Зөвлөх үйлчилгээ 1-ийн хүрээнд төлөвлөгөөний дагуу нийгмийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

Хөтөлбөрийн үе шат II-ийн хүрээнд баригдах нийгмийн барилга байгууламжуудын зураг төслийн ажлын явцын мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

№	Барилга, Дэд төвүүд	Газрын байршил	Хийгдэж буй ажлууд
1.	Спорт Цогцолбор /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 7-р хороо, /НОБГ-ын эзэмшлийн газар/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг бүрэн дуусган тендерийн баримт бичгийг бэлтгэж байна. НОБГ болон ТХН-ын хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан тус газар дээр усан спорт цогцолбор барина.
2.	240-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 7-р хороо, /Иргэний өмчлөл/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 92%-тай хийгдэж байна. Иргэний газар тул газар болон эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, иргэнтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
3.	Олон Нийтийн Хөгжлийн төв /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 7-р хороо, /Иргэний өмчлөл/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 80%-тай хийгдэж байна. Иргэний газар тул газар болон эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, иргэнтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
4.	Цэцэрлэгт хүрээлэн /Баянхошуу дэд төв/	СХД-ийн 9-р хороо, Сонгинохайрхан уулын урд бэлд /СХД-ийн тусгай хамгаалалттай бүс/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төслийг иж бүрдлээр нь урьдчилан төлөвлөсөн газарт байршлыг тооцон 100% дуусган тендерийн баримт бичгийг бэлтгэж байна.
5.	Спорт Цогцолбор /Дамбадаржаа дэд төв/	СБД-ийн 16-р хороо, /Ойн хөгжлийн төвийн эзэмшил/	<ul style="list-style-type: none"> 3.2 га талбайг тус зориулалтаар олгуулахаар ажиллаж байна. НГЗБА, НЗДТГ-аас тус байгууллагад албан хүсэлтээ хүргүүлсэн.
6.	Олон Нийтийн Хөгжлийн төв /Дамбадаржаа дэд төв/	СБД-ийн 16-р хороо, /Ойн хөгжлийн төвийн эзэмшил/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төслийн ажил дуусах шатандаа хийгдэж байна.
7.	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дамбадаржаа дэд төв/	Сүхбаатар дүүргийн 17-р хороо, /Иргэдийн өмчлөл/	<ul style="list-style-type: none"> Нийт 11 айлын газар чөлөөлөх шаардлагатай. Газар болон эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, иргэдтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Нарийвчилсан зураг төслийн ажил дуусах шатандаа хийгдэж байна.
8.	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дэнжийн мянга дэд төв/	Чингэлтэй дүүргийн 11-р хороо, /Бармон ХХК-ийн эзэмшил/	<ul style="list-style-type: none"> Бармон ХХК-ний гэр хорооллыг дахин төлөвлөх төслийн хүрээнд хамрагдсан. Бармон ХХК-тай зөвшилцөж газрыг чөлөөлнө. Нарийвчилсан зураг төслийг иж бүрдлээр нь Бармон ХХК-ийн урьдчилан төлөвлөсөн газарт байршлыг тооцон 100% дуусган тендерийн баримт бичгийг бэлтгэж байна.
9.	Цэцэрлэгт хүрээлэн /Дэнжийн мянга дэд төв/	Чингэлтэй дүүргийн 11-р хороо, /Бармон ХХК-ийн эзэмшил/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 92%-тай хийгдэж байна. Төсөлд оролцох сонирхолтой иргэдийн судалгаа хийгдэж байна.
10.	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Сэлбэ дэд төв/	СБД-ийн 14-р хороо, /Иргэдийн өмчлөл/	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 92%-тай хийгдэж байна. Төсөлд оролцох сонирхолтой иргэдийн судалгаа хийгдэж байна.

11.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийг түр хамгаалах байр	Баянзүрх дүүрэгт, /Нийслэлийн Цагдаагийн газрын эзэмшил/	• Хуульзүйн Дотоод хэргийн яам, Нийслэлийн цагдаагийн газартай хамтран газрын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.
-----	---	--	---

Төлөвлөж буй нийгмийн барилга байгууламжууд:

1. Баянхошуу дэд төв – Спорт цогцолбор

Дэд төвийн нэр	Баянхошуу дэд төв
Байршил	Сонгинохайрхан дүүргийн 9-р хороо
Зориулалт	Спорт цогцолбор /усан бассейнтай, 650 хүний суудалтай/
Зураг төслийн гүйцэтгэгч	“Бодь пропертийз” ХХК
Барилгын техникийн ерөнхий өгөгдөл	Цутгамал төмөр бетон бүтээц
Газар чөлөөлөлтөд өртөж буй нэгж талбар	ОБЕГ-н эзэмшил газар 17,000м ² орчим
Барилгажих талбай	2,282м ²
Барилгын ашигтай талбай	5690.65м ²
Бусад мэдээлэл	Гадна 200 авто машины зогсоол Зоорийн давхарт 8 авто машины зогсоол



2. Дамбадаржаа дэд төв – Спорт цогцолбор

Дэд төвийн нэр	Дамбадаржаа дэд төв
Байршил	Сүхбаатар дүүргийн 16-р хороо
Зориулалт	Спорт цогцолбор /650 хүний суудалтай/
Зураг төслийн гүйцэтгэгч	“Бодь пропертийз” ХХК
Барилгын техникийн ерөнхий өгөгдөл	Цутгамал төмөр бетон бүтээц
Газар чөлөөлөлтөд өртөж буй нэгж талбар	Мод үржүүлгийн талбайн эзэмшил газар 20,000м ² орчим
Барилгажих талбай	1315.16м ²
Барилгын ашигтай талбай	3958.98м ²
Бусад мэдээлэл	Гадна 125 авто машины зогсоол Зоорийн давхарт 8 авто машины зогсоол Хөл бөмбөгийн талбай, Сагсан бөмбөгийн талбай



3. Дамбадаржаа дэд төв – Олон нийтийн хөгжлийн төв

Дэд төвийн нэр	Дамбадаржаа дэд төв
Байршил	Сүхбаатар дүүргийн 16-р хороо
Зориулалт	Олон нийтийг хөгжүүлэх төв
Зураг төслийн гүйцэтгэгч	“Бодь пропертийз” ХХК
Барилгын техникийн ерөнхий өгөгдөл	Цутгамал төмөр бетон бүтээц
Газар чөлөөлөлтөд өртөж буй нэгж талбар	Мод үржүүлгийн талбайн эзэмшил газар 6,200м ² орчим
Барилгажих талбай	1315.16м ²
Барилгын ашигтай талбай	3958.98м ²
Бусад мэдээлэл	Concept design



4. Цэцэрлэгт хүрээлэн

Дэнжийн Мянга дэд төв

Дэд төвийн нэр	Дэнжийн мянга дэд төв
Байршил	Чингэлтэй дүүргийн 10-р хороо
Зориулалт	Цэцэрлэгт хүрээлэн
Зураг төслийн гүйцэтгэгч	“Бодь пропертийз” ХХК
Барилгын техникийн ерөнхий өгөгдөл	Түшиц, хана, хайстай, мод бут, гэрэлтүүлэг
Газар чөлөөлөлтөд өртөж буй нэгж талбар	Бармон ХХК
Тохижилт хийх талбай	1,5га
Бусад мэдээлэл	Гадна авто машины зогсоол, Хүүхдийн тоглоомын талбай, Нийтийн бие засах газар



Баянхошуу дэд төв

Дэд төвийн нэр	Баянхошуу дэд төв
Байршил	Сонгинохайрхан дүүргийн 9-р хороо
Зориулалт	Цэцэрлэгт хүрээлэн
Зураг төслийн гүйцэтгэгч	“Бодь пропертийз” ХХК
Барилгын техникийн ерөнхий өгөгдөл	Түшиц, хана, хайстай, мод бут, гэрэлтүүлэг
Газар чөлөөлөлтөнд өртөж буй нэгж талбар	Сонгинохайрхан дүүрэг
Тохжилт хийх талбай	2га
Бусад мэдээлэл	Гадна авто машины зогсоол, Хүүхдийн тоглоомын талбай



Дээрх нийгмийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг эцэслэхэд газрын асуудал шийдэгдээгүй байгаа нь хүндрэл учруулж байна. Газрын асуудал шийдэгдсэнээр эдгээр барилгуудын суурийн болон гадна шугам сүлжээний зургуудыг боловсруулах ажил хийгдсэнээр худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдэнэ. Тухайлбал, Баянхошуу, Сэлбэ, Дэнжийн мянга, Дамбадаржаа дэд төвүүдэд баригдах цэцэрлэгийн барилгуудын газрын 0 түвшнээс дээрх барилгын зургуудыг боловсруулж дууссан боловч газрын асуудлаас шалтгаалан суурийн болон гадна сүлжээний зургуудыг боловсруулах боломжгүй болсон. Мөн Баянхошуу дэд төвд баригдах спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн, Дэнжийн мянга дэд төвд төлөвлөсөн цэцэрлэгт хүрээлэн, Дамбадаржаа дэд төвд төлөвлөсөн спорт цогцолборын зураг төслүүдийг боловсруулж дуусгасан боловч газрын асуудал албан ёсоор шийдэгдэж баримт бичгээр баталгаажаагүй байна.

4. Дүгнэлт ба тулгамдаж буй асуудлууд

2019 оны 09-р сарын 30-ны байдлаар төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй дараах асуудлууд байна. Үүнд:

- 1. Төслийн санхүүжилт:** 2019 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл арга хэмжээний төсвийн саналд 68.0 тэрбум төгрөгийн санал оруулснаас 18.0 тэрбум төгрөг батлагдсан. 2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор болон Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд баригдаж буй авто зам, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир ус, холбооны шугам сүлжээ зэрэг инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд АХБ болон Нийслэлийн төсвийн хамтарсан санхүүжилттэй гэрээт ажлуудын Нийслэлийн хариуцах хөрөнгө оруулалтын санхүүжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэгч нарт гэрээний дагуу гүйцэтгэлээр санхүүжилт олгох боломжгүй нөхцөл байдал үүсч барилга угсралтын ажил зогсох, төслийн хэрэгжилт удаашрах эрсдэл үүссэн. Иймд 2019 оны IV улиралд хийгдэх ажлуудыг санхүүжүүлэх 33.9 тэрбум төгрөгийн нэмэлт төсөв зайлшгүй шаардлагатай байна. Одоогоор БУА-ын гүйцэтгэлээр төлбөрийн хүсэлт ирүүлсэн, төсөв хүрэлцэхгүй шалтгааны улмаас Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжгүй 3.9 тэрбум төгрөгийн төлбөрийн хүсэлтүүд хүлээгдэж байна.
- 2. Кадастрын зургийн өөрчлөлт:** Төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах авто зам, инженерийн шугам сүлжээний зурваст өртсөн 258 нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг мэдээллийн санд бүртгүүлэхээр албан бичгийг 2018 оны 11 дүгээр сараас хойш удаа дараа явуулсан. Одоогийн байдлаар 120 гаруй иргэний мэдээллийг шинэчилсэн бөгөөд мэдээлэл шинэчлэх ажлыг 1 хүн хариуцан гүйцэтгэж байгаа нь хүндрэл учруулж байна.
- 3. Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй иргэдэд газар олгох:** АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын дагуу боловсруулан баталсан “Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө” -нд заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөж, нүүх шаардлагатай болсон өөрийн гэсэн газрын эрхгүй өрх тус бүрд одоогийн амьдарч буй газраас нь дордуулахгүй нөхцөлтэй газар олгох шаардлагатай гэж заасан. Үүний дагуу нөлөөлөлд өртсөн газрын эрхгүй амьдарч байгаад нүүсэн болон нүүх шаардлагатай болсон 253 өрхийн газрын асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.
- 4. Нийгмийн барилга байгууламжууд баригдах газрын асуудал:** Тайлангийн хугацаанд Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд Баянхошуу дэд төвд буюу ОБЕГ-ын хашаан дахь сул талбайд төлөвлөсөн спорт цогцолбор, Сонгинохайрхан уулын бэлд (улсын тусгай хамгаалалттай газар) төлөвлөсөн цэцэрлэгт хүрээлэн болон Дамбадаржаа дэд төвд буюу БОАЖЯ-ны харьяа Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ийн эзэмшлийн газарт төлөвлөсөн спорт цогцолборын газрын асуудлыг шийдвэрлэн баримтаар баталгаажуулаагүйн улмаас эдгээр барилгуудын нарийвчилсан зураг төслийн ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тул яаралтай шийдвэрлэх шаардлагатай.

Төслийн санхүүжилт болон Хөтөлбөрийн II үе шатны хүрээнд төлөвлөсөн нийгмийн барилга байгууламжуудын газрын асуудлаас үүдэн төслийн ажил зогсонги байдалд орох эрсдэл өндөр байна. Төслийн санхүүжилтийн асуудлыг 2020 оны төсөвт хангалттай суулган батлуулах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь төслийг хугацаанд нь хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болно.



4. Хавсралтууд

Д/д	Хавсралтын нэр	Хуудас
1	Баянхошуу дэд төв – барилга угсралтын ажлын явцын зургууд	21
2	Сэлбэ дэд төв - барилга угсралтын ажлын явцын зургууд	26
3	ЕХОБ-ны санхүүжилттэй барилга угсралтын ажлын явцын зургууд	33

Баянхошуу дэд төв – Барилга угсралтын ажлын явцын зургууд

1. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил

Гэрээний дугаар: ВНФ06

Гүйцэтгэгч: “ЧММ” ХХК, “Эс Энд Эй Трейд” ХХК-иудын түншлэл



Угсралтын ажлын гэрээг ЧММ ХХК, Эс Энд Эй трейд ХХК-ийн түншлэлтэй 2018 оны 3-р сарын 09-нд байгуулж, ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг Эрчим Хүчний Яамнаас 2018 оны 5-р сарын 10-ны өдөр авсан.

Дулааны 11и магистраль 2ф500мм-ийн 1,6 км шугамыг буулгаж 2ф700мм болгон өргөтгөж, шинэчлэх ажлыг бүрэн хийж дуусгасан. Тохижилт нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. 2019 оны 05 сард Содон хорооллын хойд уулзвараас ханын материалын эцэс хүртэлх 2ф400мм-ийн 1,6 км шугамыг буулгаж 2ф600мм болгон өргөтгөж, шинэчилсэн.

Зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу дулааны шугамд ашиглагдах яндан хоолойг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх ажил удаашралтай, олон шат дамжлагатай зэргээс шалтгаалж материал татан авалт хийх бүрт 12-45 хоног зарцуулж байсан нь төлөвлөгөөний дагуу 2018 онд багтаан дуусгаж бүрэн ашиглалтанд оруулахгүй боломжгүй байдалд хүргэсэн.

Улмаар 2019 оны 8 сард барилга угсралтын ажил дуусч, 2019.09.06-ны өдөр байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажилласан.

2. Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: BSF05 Багц 1

Гүйцэтгэгч: “Ус Орчин” ХХК

Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянхошуу дэд төвд барьсан 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг Нийслэлийн газрын албанаас 2018 оны 04 сарын

16-ны өдөр, МЗХ2018/07-49 тоот архитектур төлөвлөлтийн даалгаврыг 2018 оны 04 сарын 20-нд, 138/2018 тоот барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2018 оны 05 сарын 07-ны өдөр НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.



3. Баянхошуу дэд төвд барих Бизнес инкубатор, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга

Гэрээний дугаар: BSDF05, Багц 2

Гүйцэтгэгч: “Томо Бюлдинг” ХХК, “Би Эм Си Эм” ХХК-иудын түншлэл

Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянхошуу дэд төвд барьж буй бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг Нийслэлийн газрын албанаас 2018 оны 4-р сарын 16-ны өдөр, МЗХ2018/07-50 тоот архитектур төлөвлөлтийн даалгаврыг 2018 оны 4-р сарын 20-нд, 138/2018 тоот барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2018 оны 5-р сарын 07-ны өдөр НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.





4. Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: BSDF07, Багц 1

Гүйцэтгэгч: “Хангилцаг” ХХК

Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын 119/2018 тоот барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг журмын дагуу НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас 2018 оны 5-р сарын 01-ний өдөр авч, 2018 оны 4-р сарын 16-наас барилга угсралтын бэлтгэл ажлын хангаж далангийн ажлыг гүйцэтгэсэн.



5. Баянхошуу дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

Гэрээний дугаар: BSWR10, Багц 1

Гүйцэтгэгч: “Бумбод” ХХК, “Одкон” ХХК-иудын түншлэл





6. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах шинэ дулааны магистраль шугамын ажил

Гэрээний дугаар: ВНF06В

Гүйцэтгэгч: БНСУ-н “Жангхан Инженеринг” ХХК, КDНЕС ХХК, болон Монгол улсын Одкон Холдинг ХХК-иудын түншлэл

Дулааны шинэ шугамын бэлтгэл ажил хангах, материал таталтын ажил дуусч барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.



Дулааны шугамын төлөвлөлт



7. Баянхошуу дэд төвийн усан хангамж, ариутгах татуурга, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, бараа тоног төхөөрөмж нийлүүлэх болон суурилуулах ажил

Гэрээний дугаар: WSC16A

Гүйцэтгэгч: “Одкон Холдинг” ХХК, “Улаанбаатар Барилга” ХХК-ийн түншлэл

Сонгинохайрхан дүүргийн 7-р хороо, Баянхошуунд байрлалтай, нийт 720 өрх амьдардаг “Хилчин хотхон”-ыг төвийн дулаанд шинээр холболоо. Хилчин хотхоныг ашиглалтад орсноос хойш 10 жилийн туршид уурын зуухаар халааж, жилд тэрбум гаруй төгрөгийн татаастай, өвөлдөө 7000 тонн гаруй нүүрс хэрэглэдэг байсан юм.

Мөн энэхүү ажлын хүрээнд Баянхошуу дэд төвийн 227, 163, 78-р цэцэрлэгийн барилгууд, 76-р сургууль, дүүргийн Эрүүл мэндийн 3-р амбулатори гэх мэт олон барилга байгууламжийг төвийн дулаантай холбох ажлууд үе шаттайгаар хийгдэх ба зураг төслийн ажил зөвшилцөх шатандаа байна.



Сэлбэ дэд төв - Барилга угсралтын ажлын явцын зургууд

1. Сэлбэ дэд төвд баригдах 24 м, 30 м, 60 м-ийн урттай 3 ширхэг төмөрбетон гүүрний барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: SBR08

Гүйцэтгэгч: "ЗМЗ" ХХК

2018 оны 10-р сарын 15-ны өдөр ЗМЗ ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд өвлийн улирлын сул зогсолтын ашиглан “Улаанбаатар БҮК” бетон хийцийн үйлдвэрт 3 төмөрбетон гүүрний нийт 42 үндсэн дам нуруу болон металл хайс, хашлагыг цутгаж бэлэн болгосон.

2019 оны 3-р сарын 20-ны өдөр 3 гүүрний барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийн НХБХГ-аас авч ажлыг барилгын талбайд эхлүүлсэн.



2. Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил үе шат 1

Гэрээний дугаар: SRDH11

Гүйцэтгэгч: “Вайт Финикс” ХХК, “Хасу Мегаватт” ХХК, “Эвт Трак” ХХК-иудын түншлэл



3. Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил үе шат 2

Гэрээний дугаар: SRDH14

Гүйцэтгэгч: “Набсан” ХХК, “Тэргүүн инвест” ХХК, “Тэгш плант” ХХК-иудын түншлэл





СЭЛБЭ
ДУЛААНЫ ШУГАМ



СЭЛБЭ
БОХИР УСНЫ ШУГАМ



Набсан ХХК, Тэгш Плант болон Тэргүүн Инвест ХХК-ийн түншлэлийн 244/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас 2018 оны 6-р сарын 08-ны өдөр авч, нүүлгэн шилжүүлэлт хийсэн хэсэгт ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

4. Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус дамжуулах шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

Гэрээний дугаар: BSWR10, Багц 2

Гүйцэтгэгч: “Санжат” ХХК



Барилга угсралтын 228/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас 2018 оны 05 сарын 06-ны өдөр авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

1000м³ хүчин чадалтай усан сангийн төмөрбетон хийцийн цутгалт бүрэн хийгдэж, гадна ус тусгаарлалт, дулаан тусгаарлалтын ажлууд бүрэн хийгдсэн. $Q=1.042\text{т}^3/\text{мин}$ х 69 мН хүчин чадалтай ажлын 2, нөөцийн 1 насос бүхий насос станцын барилгын барилга угсралт бүрэн дуусч, дотор засал, тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж байна. Тоноглолын худалдан авалт, таталтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. 1.69км урт дамжуулах шугамын суурилуулалтын ажил бүрэн хийгдсэн. Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

5. Сэлбэ дэд төвийн дулааны станцын зураг төсөл, ханган нийлүүлэлт, барилга угсралтыг гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ

Гэрээний дугаар: SHF06

Гүйцэтгэгч: "Хүрд" ХК, "Шиншиан Гонгшен бойлер" ХХК-ийн түншлэл

Гэрээний нөхцөл ёсоор 2018.11.24-ны өдөр Нийслэлээс урьдчилгаа төлбөр шилжсэнээр гэрээ хүчин төгөлдөр болж гэрээний эхлэх өдөр тоологдсон.





Гүйцэтгэгчтэй хийсэн олон удаагийн уулзалтаар БНХАУ-ын "Шиншиан Гонгшен бойлер" ХХК зураг төслийг боловсруулж буй гэж удаа дараа мэдэгдсэн боловч уг компани нь зураг төслийг гүйцэтгэхдээ төлөвлөсөн хугацаанаас хоцорсон. Иймд, 2018 оны 03 сарын 15-наас түншлэлийн толгой компани болох "Хүрд" ХК нь өөрсдөө Монголд ажлын зураг төслийг боловсруулахаар болж “Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн”-гээр гүйцэтгүүлж, дулааны станцын ажлын зураг төсөлд Эрчим Хүчний Хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулсан.

Магадлалаар баталгаажсан БА, ББ зурагт үндэслэн барилгын суурийн ажлыг эхлүүлсэн бөгөөд дулааны станцын тогооны барилгын баганан суурийн цутгалтын ажил хийгдэж байна. Дулааны станцын тоног төхөөрөмж, бараа материалын захиалга хийгдэж, бэлтгэл ажлууд бүрэн хангагдсан.

6. Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: SSF05 Багц 1

Гүйцэтгэгч: Цаст Констракшн ХХК

2019 оны 1-р сарын 17-ны өдөр Цаст Констракшн ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд өвлийн улирлын сул зогсолтын ашиглан бэлтгэл ажлуудыг хангасан. Барилгын талбайд өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх, барилгын түр хашаа татах, түр цахилгааны техникийн нөхцөл авах, гүйцэтгэгч түр кемп барих ажлыг бүрэн хийж, барилгын суурийн газар шорооны ажил, суурь цутгах ажил дууссан. Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.





7. Сэлбэ дэд төвд барих Бизнес инкубатор, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: SSF05 Багц 2

Гүйцэтгэгч: “Бридж Костракшн” ХХК болон “Монхас” ХХК-ийн түншлэл

2019 оны 1-р сарын 17-ны өдөр “Бридж Костракшн” ХХК болон “Монхас” ХХК-ийн түншлэлтэй гэрээ байгуулсан. Барилгын суурийн ажлын явцад хөрсөнд хад чулуу тооцоолсноос их гарсан тул суурийн газар шорооны ажил тооцоолсноос илүү хугацаа шаардсан. Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.



ЕХОБ-ны санхүүжилттэй барилга угсралтын ажлын явцын зургууд

1. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил

Гэрээний дугаар: WWTPR01

Гүйцэтгэгч: “Эс Энд Эй Трейд” ХХК, “Набсан” ХХК-иудын түншлэл



Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилгыг дотор инженерийн шугам сүлжээний хамт шинэчлэн барих болон аэротанкийн бетон хийцийн эвдрэлийг засах, цэвэрлэгээний чанарыг сайжруулах агаарын диффузер, селектор нэмж суурилуулав.


Аэротанкийн хувьд: 1 дүгээр аэротанкийг 4-р сарын 15-наас бэлтгэл ажил ханган ойролцоогоор 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажилласан. Суллах үйл ажиллагаа, цэвэрлэгээ, бетон хийцийн хийцлэл/зураг төсөл, угсралтын технологийг сайжруулах, шинээр суурилуулах селектор, холигч, диффузер зэргээс хамаарч төлөвлөсөн хугацаанаас нэг сараар хоцорч ашиглалтанд оруулсан. Нэгдүгээр аэротанкийн ажлаас хангалттай туршлага хуримтлуулсан тул 2018 оны 7-р сарын 25-наас 2 болон 3-р аэротанкийн засварын ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн болно. 2019 оны 3-р сарын 15-наас аэротанк №4-н ажлыг эхлүүлж дуусгасан бөгөөд одоо аэротанк №5-г суллаж засвар шинэчлэлтийн ажлыг эхлүүлэв.

2. Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: WSNR17C

Гүйцэтгэгч: “Модерн Хас” ХХК, “Монгол Менежмент” ХХК-иудын түншлэл

Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас 2018 оны 07 сарын 17-нд авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 543 метр урттай Ф400мм-ийн зөөлөн ширмэн ариутгах татуургын шугамаас 460 метр шугам угсарч суурилуулав.



3. Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх HDPE ф900мм-ийн 4010 метр цэвэр ус дамжуулах гол шугамын болон ф600мм-ийн 1684.23 метр урт “96” бохир ус зайлуулах зөөлөн ширмэн яндан хоолой шугамын барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: WSNR17A

Гүйцэтгэгч: “Грийн ресурс” ХХК



162/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас 2018 оны 5-р сарын 14-нд авсан.

Цэвэр усны яндан хоолой нь БНХАУ-ын Шандун мужийн Linyi хотын Teng Yuan үйлдвэрт үйлдвэрлэгдсэн, хөндлөнгийн SGS (Tianjin) лабораториор баталгаажсан болно. Барилга угсралтын ажил удаашралтай байгаа гол шалтгаан нь импортын албан татвараас чөлөөлөгдөх явц удаашралтай, олон шат дамжлагатай байгаагаас хугацаа алдаж байна.

Гүйцэтгэгч Грийн Ресурс ХХК-ийн зүгээс энэ онд цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийж гүйцэтгэв. Газар чөлөөлөлт, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажлууд удаашралтай байгаагаас гүйцэтгэгч байгууллага гэрээт ажлаа гүйцэтгэх нөхцөл боломжоор хангагдах боломжгүй байдал бий болж хугацааны хувьд хоцрогдол үүсч байна.

4. Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 7054 метр урттай ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: WSNR17B

Гүйцэтгэгч: “Монинжбар” ХХК

Яндан хоолой хаалт арматур үйлдвэрлэл дуусч, татан авалт хийгдэж байна. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХБХГ /хуучнаар НХТЕТГ/-аас 2018 оны 6-р сарын 05-нд авсан. Одоогоор барилга угсралтын талбайд 335м урт HDPE ф600мм цэвэр усны хоолой угсарч суурилуулав.



5. Ус Сувгийн Удирдах Газрын үйл ажиллагааг сайжруулах төсөл

Гэрээний дугаар: WWOI


Гүйцэтгэгч: “Комфорт Импекс” ХХК

УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах дэд төслийн хүрээнд Үйлдвэр, Мах, Төв болон Гачуурт насос станцуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, түгээх сүлжээний удирдлагын болон хэмжих худгуудын барилга угсралт, УСУГ-ын төвд удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдлыг илрүүлэх систем суурилуулж ашиглалтад оруулах зэрэг ажлуудыг 100% хийж гүйцэтгэсэн. Шилэн кабель суурилуулалтын ажил хийгдэж дууссан. Үйлдвэрийн станцын удирдлагын системийг ашиглалтад оруулж ажиллагааг жигдрүүлснээр 1 ба 2-р өргөгчийн насос станцыг хянан удирдаж хяналтын хаалт угсралтын шинэчилсэн графикийг холбогдох хүмүүсээр батлуулан ажиллаж байна. УСУГ нэгдсэн удирдлагын төвийн програм хангамжийн ажлыг 100% гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд дараах дэд ажлуудыг бүрэн хийж дууссан. Үүнд:


❖ **Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн ажлын хүрээнд:**

- Ус хангамжийн эх үүсвэрүүдэд насосын давтамж хувиргагч, шилэн кабель, өргөлтийн насосууд суурилуулж автоматжуулалт хийгдсэн.
- Ус хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 худгийн 30 худгийг шинээр барьж, 10 худгийг шинэчлэн засварласан
- Төв цэвэрлэх байгууламжийн SCADA программ, шилэн кабелийн суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй уг дэд төслийн хүрээнд Төвийн эх үүсвэрийн 6кВ-ын 750кВт-ын хүчин чадал бүхий цахилгаан хөдөлгүүрт Harvest Schneider брэндийн давтамж хувиргагч суурилуулснаар 3 насос хөдөлгүүрийг удирдан ажиллуулах бүрэн боломжтой болсон.



Давтамж хувиргагчийн ерөнхий удирдлагын дэлгэц дээр үндсэн үзүүлэлт болон шаардлагатай параметрууд гардаг бөгөөд насос болон цахилгаан хөдөлгүүрийг гаралтын шугам дээр тавигдсан даралтын мэдрэгчийн мэдээллээр удирдан ажиллуулж байна. Энэхүү ухаалаг төхөөрөмж нь дэлгэц дээр шаардлагатай байгаа даралтыг өгснөөр уг тоноглол өгөгдсөн утгыг барьж ажилладаг тул усны алдагдлыг бууруулахад чухал ач холбогдолтой.



1м3 ус олборлон түгээхэд зарцуулж буй цахилгаан эрчим хүч /Төв станц /

Сар	2015	2016	2017	2018
1	0.72	0.70	0.76	0.65
2	0.71	0.75	0.67	0.59
3	0.68	0.64	0.68	0.55
4	0.60	0.68	0.55	0.49
5	0.80	0.60	0.61	0.53
6	0.62	0.69	0.62	0.46
7	0.61	0.60	0.59	0.55
8	0.60	0.64	0.59	0.51
9	0.69	0.67	0.52	0.41
10	0.62	0.59	0.54	0.45
11	0.68	0.74	0.55	0.37
12	0.65	0.55	0.56	
	0.66	0.65	0.61	0.51


Хүснэгт 2. Хэмжих хэрэгсэл болон электрон тоолуураар гарсан тоон үзүүлэлт

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй уялдуулан давтамж хувиргагчийг суурилуулсан нь энэ хуулийг хэрэгжүүлэхэд дөхөм болсон. Давтамж хувиргагчийг суурилуулснаар өмнөх 3 жилийн дунджаар 1м³ усыг 0,64кВт/цаг эрчим хүчээр олборлон түгээдэг байсан бол 2018 онд 0,51кВт/цаг болж 0,12кВт/цагийн эрчим хүчээр буурч эрчим хүчний хэмнэлттэй ажиллаж эхэлсэн байна.

❖ Автоматжуулалтын ажил ы

УСУГ-ын ус хангамжийн 4 эх үүсвэрийн станцуудын алсын удирдлагын шилэн кабель, холболтын төхөөрөмжүүдийг суурилуулах ажил бүрэн дууссан. Диспетчерийн өрөөнд хянан ажиллаж байна. УСУГ-н шинээр барьж буй төв оффисын барилга ашиглалтад орох үед нэгдсэн удирдлагын төв, диспетчерийн дэлгэцийг суурилуулах болно.


Эрчим хүчний хэмнэлттэй орчин үеийн шаардлагад нийцсэн цахилгаан тоног төхөөрөмж нэвтрүүлэн ус хангамжийн эх үүсвэрүүдэд насосын давтамж хувиргагч, шилэн кабель, өргөлтийн насосууд суурилуулж автоматжуулалт хийж, ус хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 худгийн 30 худгийг шинээр барьж, 10 худгийг шинэчлэн засварлан Төв цэвэрлэх байгууламжийн шилэн кабелийн суурилуулалтын ажлыг SCADA системийн хамт хийж гүйцэтгэсэн. Ингэснээр эрчим хүчний хэрэглээ буурч 0,12кВт/цагийн хэмнэлттэй ажиллаж эхэлсэн.



Махын эх үүсвэрийн станц



Гачууртын эх үүсвэрийн станц



Үйлдвэрийн эх үүсвэрийн станц